

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ИХ СУРГУУЛЬ

Бат-Эрдэнийн Ариунзаяа

**ГЕПАТИТИЙН С ВИРҮСИЙН АРХАГ ХАЛДВАРТАЙ ӨВЧТӨНҮҮДЭД
ЭСИЙН ДАРХЛААНЫ ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТИЙГ ТОДОРХОЙЛСОН ДҮН**

Е-720218. Дархлаа судлал

**Анагаах ухааны магистрын зэрэг
горилсон нэг сэдэвт бүтээл**

**Улаанбаатар
2009 он**

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ИХ СУРГУУЛЬ

Гар бичмэлийн эрхтэй ©

Бат-Эрдэнийн Ариунзаяа

**ГЕПАТИТИЙН С ВИРҮСИЙН АРХАГ ХАЛДВАРТАЙ ӨВЧТӨНҮҮДЭД
ЭСИЙН ДАРХЛААНЫ ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТИЙГ ТОДОРХОЙЛСОН ДҮН**

Е-720218. Дархлаа судлал

**Анагаах ухааны магистрын зэрэг
горилсон нэг сэдэвт бүтээл**

Магистрын ажлын удирдагч:

С. Цогтсайхан

АУ-ны доктор (Ph.D), дэд профессор

Магистрын ажлын зөвлөх:

Б. Баярмагнай

АУ-ны доктор (Ph.D)

Албан ёсны шүүмжлэгч:

Л. Мөнхтулга

АУ-ны доктор (Ph.D)

Улаанбаатар

2009 он

УДИРТГАЛ

Судалгааны ажлын үндэслэл

Вирүст гепатит нь гепатитийн А, В, С, D, E зэрэг вирүсээс үүссэн элэгний үрэвсэл бөгөөд манай орны төдийгүй дэлхий нийтийн анхаарлыг татсан, эрүүл мэндийн тулгамдсан асуудлын нэг юм [WHO Global surveillance and control of hepatitis C. Report of a WHO 1999, Я. Дагвадорж нар. 2004, О. Баатархүү 2006]. Эмнэлзүйн шинж төрх нь ижил төстэй хэдий ч элгийг сонгомлоор гэмтээдэг, бүтэц зохион байгуулалт, төрөл зүйлээрээ эрс ялгаатай, гепатит үүсгэдэг А, В, С, D, E, F, G, TTV мөн SEN зэрэг наад зах нь 9 төрөл вирүс байгаа нь нэгэнтээ тогтоогдсон бөгөөд эмнэлгийн практикт элбэг тохиолддог нь А, В, С, D, E гепатит юм [Cossart Y., 2000, Kiyosawa K., Tanaka E., 1999, Pagliaro L., Peri V., Linea C. et al. 1999]. Эдгээр вирүст гепатитаас А болон В нь урьдчилан сэргийлэх тарилгатай, E гепатит нь архагшихгүй тул өнөө үед практикийн хувьд хамгийн төвөгтэй нь гепатитийн С вирүс (Hepatitis C Virus-HCV)-ийн халдвар болно [Poynard T., Bedossa P., Opolon P., 1997].

ДЭМБ-ын мэдээгээр дэлхий дээр 180 орчим сая хүн HCV-ийн халдвартай байгаа бөгөөд энэ нь дэлхийн бүх хүн амын 3%-ийг эзэлж байна [WHO Global surveillance and control of hepatitis C. report of a WHO]. Монгол улсын хүн амын дунд HCV-ийн халдварын тархалт 10.7-19.6% бөгөөд улс орныг хамарсан нутагшмал шинжтэйг олон тооны судалгааны үр дүн харуулсан байна [Д. Алимаа 1987, Ц. Оюунсүрэн нар. 1996, Ж. Оюунбилэг нар. 1992, О. Баатархүү 2006].

HCV-ийн халдварын 70-аас доошгүй хувь нь архагшиж, улмаар 20-25 жилийн дараа элэгний хатуурал, 25-30 жилийн дараа элэгний анхдагч өмөнд шилждэг болох нь тогтоогджээ [Майер К.П., 2004, Hoofnagle J.H. et al. 2002].

Монгол орны 1995-2003 оны өвчлөлийн бүтцэд хавдрын өвчлөл тогтмол 2-р байранд орж байгаа бөгөөд хавдрын өвчлөлийн бүтцийг авч үзвэл элэгний хорт хавдар байнга нэгдүгээрт орж байна [Р. Сандуйжав 2004]. Элэгний хавдарт хүргэх үндсэн шалтгаан нь гепатитийн В болон С вирүсийн халдвар болох тухай судлаачид олон талаар тогтоосон билээ. Ийнхүү вирүст гепатит болон түүний уршгаас үүдсэн өвчин эмгэг манай хүн амын өвчлөл, нас баралтын дотор онцгой байр эзэлсэн хэвээр байгаа, цаашид ч өсөх хандлагатайн зэрэгцээ тэдгээрийг оношлох, эмчлэх мөн сэргийлэх асуудал бүрэн шийдвэрлэгдээгүй байна.

HCV-ийн халдвар даамжирч архагших нь халдварт өртсөн бодгалийн дархлааны чадамжтай ихээхэн холбоотой байдаг. Манай оронд HCV-ийн халдварын үеийн вирүсийн шинж төрх, зан үйл, тархалтын талаар хангалттай тооны судалгаа хийсэн боловч вирүс-эзэн организмын хоорондын харилцан үйлчлэлийн шинж байдлыг үнэлсэн судалгааны ажил хомс байна. Эдгээр нөхцөл байдал нь энэ судалгааны ажлыг хийх үндэслэл болсон юм.

Судалгааны ажлын зорилго, зорилт

Бид энэ судалгааны ажилдаа гепатитийн С вирүсийн архаг халдвартай өвчтөний эсийн дархлааны зарим үзүүлэлтийг үнэлэх зорилго тавьсан юм.

Энэ зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн тавьж шийдвэрлэв. Үүнд:

1. HCV-ийн архаг халдвартай өвчтөний захын цусан дахь Т лимфоцит эсийн дэд бүлгийн тоо (CD4, CD8, CD3; эс/мм³), харьцаа (CD4/CD8), захын цусны Т лимфоцит эсийн бласттрансформацид орох идэвхийг тодорхойлох.

2. Захын цусан дахь Т эсийн дэд бүлгийн тоо, харьцаа ба Т лимфоцит эсийн бласттрансформацид орох идэвхтэй холбоотой хүчин зүйлсийг тогтоох.

Судалгааны ажлын шинэлэг тал

Монгол улсын хүн амын дунд өргөн тархсан, алсын урхаг ихтэй, нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлын нэг болох HCV-ийн архаг халдвартай өвчтөнүүдэд эсийн дархлаа чадамжийг судлах оролдлого хийсэнд энэ судалгааны ажлын шинэлэг тал оршино.

Судалгааны практик ач холбогдол

HCV-ийн архаг халдварын үеийн дархлааны чадамжийг зөвхөн өвөрмөц эсрэгбиеийн төвшингээр төдийгүй эсийн дархлааны чадамжаар үнэлэх нь вирус-эзэн организмын хоорондын харилцан үйлчлэлийн шинж байдлыг тодорхойлоход илүү ач холбогдолтой болохыг тогтоосонд энэ судалгааны ажлын практик ач холбогдол оршино.

Хамгаалахаар дэвшүүлж буй үндсэн асуудал

1. HCV-ийн архаг халдварын үед вирусийн эсрэг үүссэн өвөрмөц эсрэгбиеийн агууламж болон эсийн дархлаа чадамжийн хамаарал
2. HCV-ийн архаг халдварын үеийн эмнэлзүйн шинж ба эсийн дархлаа чадамжийн хамаарал

Судалгааны ажлын үр дүнг хэлэлцүүлсэн байдал

- Бичил амь-Дархлаа судлалын тэнхмийн 2008 оны 05-р сарын 07-ны өдрийн хурал (судалгааны сэдэв, аргачлалыг батлав)
- Бичил амь-Дархлаа судлалын тэнхмийн 2009 оны 05-р сарын 6-ны өдрийн хурал (судалгааны үр дүнгийн хэлэлцүүлэг)
- ЭМШУИС-ийн Био-Анагаахын салбарын эрдмийн чуулган, Улаанбаатар, 2009 оны 4-р сар

Судалгааны ажлын сэдвээр нийтлэгдсэн бүтээл

- Б. Ариунзаяа, Б. Баттүвшин, Г. Сарангоо, Б. Баярмагнай, С. Цогтсайхан, Я. Дагвадорж “Гепатитийн С вирусийн архаг халдвартай өвчтөнүүдийн эсийн дархлааны төлөв” Эрүүл мэндийн шинжлэх ухаан сэтгүүл №10 (хэвлэлтэнд)
- Б. Ариунзаяа, Б. Баттүвшин, Г. Сарангоо, Б. Баярмагнай, С. Цогтсайхан, Я. Дагвадорж “Гепатитийн С вирусийн архаг халдвартай өвчтөнүүдэд шингэний болон эсийн дархлааны зарим үзүүлэлтүүдийг тодорхойлсон дүн”. Халдварт Өвчин Судлалын Монголын сэтгүүл. 2009:1(26) (хэвлэлтэнд)
- Ariunzaya B., Battuvshin B., Tsogtsaikhan S., Bayarmagnai B., Sarangua G., Dagwadorj Ya. “Determination of T cell subsets in patients with chronic HCV infection” First International Conference on “Current Advances in Medical Microbiology and Immunology”. Ulaanbaatar 2008. Abstracts. pp 5-6